

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтэс 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БНА-2023/182/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Баянхонгор хот 2023.02.17	Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn Аудитын менежер: А.Цээням Утас: 99442140 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn Аудитор: Б.Нарангэрэл Утас: 99009293 Цахим хаяг: Narangerelb@audit.gov.mn Цахим хуудас: www.audit.mn
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	10
4. АУДИТЫН ТАЙЛАН	13
4.1 Ерөнхий зүйл.....	13
4.2 Материаллаг байдал	13
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	13
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	13
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	14
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	14
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	14
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	14
5.1 Зөвлөмж.....	14
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	15

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584
Цахим шуудан: procurement.bayankhongor@audit.gov.mn

2023.02.15 № 2/19

танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтсийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтсийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан.

Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 2 зорилтын хүрээнд 16 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 98.1 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Шалгагдагч

D- alban bichig 2022 A4 TOOT

005020155

байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан. Танилцахад материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Б.МӨНХБАТ

D- alban bichig 2022 A4 TOOT

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	3,064,430.10	3,868,110.10
35	БАРАА МАТЕРИАЛ	3,064,430.10	3,868,110.10
35400	Хангамжийн материал	3,064,430.10	3,868,110.10
35410	Бичиг хэргийн материал	1,029,520.00	1,434,000.00
35420	Аж ахуйн материал	2,034,910.10	2,434,110.10
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	27,736,640.54	124,047,140.34
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	27,736,640.54	124,047,140.34
39200	Биет хөрөнгө	27,736,640.54	124,047,140.34
39203	Авто-тээврийн хэрэгсэл	40,000,000.00	120,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-40,000,000.00	-44,666,666.69
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	55,542,654.27	85,242,642.27
39206	Хуримтлагдсан элэгдэл	-28,442,013.73	-37,092,835.24
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	6,489,730.00	6,489,730.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-5,853,730.00	-5,925,730.00
39301	Програм хангамж	450,000.00	450,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-450,000.00	-450,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	30,801,070.64	127,915,250.44
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	0	2,673,756.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0	2,673,756.00
41300	Өглөг	0	2,673,756.00
41360	Бусад өглөг	0	2,673,756.00
41361	Байгууллагад төлөх өглөг	0	281,660.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	0	2,392,096.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	30,801,070.64	125,241,494.44
51	Засгийн газрын хувь оролцоо	30,801,070.64	125,241,494.44
51200	Хуримтлагдсан үр дүн	30,801,070.64	125,241,494.44
51210	Өмнөх үеийн үр дүн	40,284,408.36	30,801,070.64
51220	Тайлант үеийн үр дүн	-9,483,337.72	94,440,423.80
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	30,801,070.64	127,915,250.44

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	267,061,818.00	481,555,436.67
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	8,235,900.00	110,054,445.67
120	Нийтлэг татварын бус орлого	8,235,900.00	110,054,445.67
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	7,913,400.00	109,577,904.67
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	7,913,400.00	109,577,904.67
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	322,500.00	476,541.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	258,825,918.00	371,500,991.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	111,900,500.00	110,529,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	111,900,500.00	110,529,700.00

Баянхонгор аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтэс 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	146,925,418.00	260,971,291.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	13,000,000.00	10,600,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	133,925,418.00	250,325,695.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	0	45,596.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	276,545,155.72	387,115,012.87
21	УРСГАЛ ЗАРДАЛ	276,545,155.72	387,115,012.87
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	270,261,139.72	376,500,363.17
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	91,306,361.00	88,564,661.00
210101	Үндсэн цалин	61,336,444.00	58,789,869.00
210102	Нэмэгдэл	23,105,937.00	22,058,316.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,933,000.00	3,681,000.00
210104	Урамшуулал	2,930,980.00	4,035,476.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	11,863,995.00	11,213,376.00
210201	Тэтгэврийн даатгал	8,163,795.00	7,374,141.00
210202	Тэтгэмжийн даатгал	925,100.00	1,041,635.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	740,000.00	746,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	185,000.00	186,500.00
210205	Эрүүл мэндийн даатгал	1,850,100.00	1,865,100.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,954,200.00	758,520.00
210401	Бичиг хэрэг	517,700.00	205,520.00
210402	Тээвэр, шатахуун	718,200.00	0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	491,600.00	448,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	226,700.00	104,800.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,980,000.00	2,521,300.00
210604	Урсгал засвар	2,980,000.00	2,521,300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	157,146,056.00	260,210,101.30
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	156,075,039.00	259,186,234.30
210803	Даатгалын үйлчилгээ	96,525.00	242,350.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	169,092.00	71,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	0
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	783,400.00	710,017.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,010,527.72	13,232,404.87
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	297,400.00	0
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	4,713,127.72	13,232,404.87
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,284,016.00	10,614,649.70
2132	Бусад урсгал шилжүүлэг	190,000.00	4,800,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	190,000.00	4,800,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	6,094,016.00	5,814,649.70
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,850,437.00	5,763,431.00
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	4,243,579.00	51,218.70
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	-9,483,337.72	94,440,423.80
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-9,483,337.72	94,440,423.80

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	261,825,918.00	371,500,991.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	261,825,918.00	371,500,991.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	111,900,500.00	110,529,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	111,900,500.00	110,529,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	149,925,418.00	260,971,291.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	13,000,000.00	10,600,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	133,925,418.00	250,325,695.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,000,000.00	45,596.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	261,825,918.00	371,500,991.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	261,825,918.00	371,500,991.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	255,541,902.00	360,886,341.30
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	91,841,964.00	88,564,661.00
210101	Үндсэн цалин	59,545,364.00	58,789,869.00
210102	Нэмэгдэл	23,429,200.00	22,058,316.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,399,800.00	3,681,000.00
210104	Урамшуулал	4,467,600.00	4,035,476.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	11,328,392.00	11,104,241.00
210201	Тэтгэврийн даатгал	7,628,192.00	7,374,141.00
210202	Тэтгэмжийн даатгал	925,100.00	932,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	740,000.00	746,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	185,000.00	186,500.00
210205	Эрүүл мэндийн даатгал	1,850,100.00	1,865,100.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2,183,390.00	1,223,300.00
210401	Бичиг хэрэг	514,300.00	216,100.00
210402	Тээвэр, шатахуун	718,200.00	208,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	533,300.00	448,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	417,590.00	351,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,000,000.00	2,521,300.00
210604	Урсгал засвар	3,000,000.00	2,521,300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	146,887,756.00	257,220,439.30
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	145,813,139.00	256,194,322.30
210803	Даатгалын үйлчилгээ	180,617.00	168,100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	85,000.00	71,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	0
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	787,000.00	786,517.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	300,400.00	252,400.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	300,400.00	252,400.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,284,016.00	10,614,649.70
2132	Бусад урсгал шилжүүлэг	190,000.00	4,800,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	190,000.00	4,800,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	6,094,016.00	5,814,649.70
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,850,437.00	5,763,431.00
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	4,243,579.00	51,218.70

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0	40,284,408.36	40,284,408.36
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0	40,284,408.36	40,284,408.36
9	Тайлант үеийн үр дүн	0	-9,483,337.72	-9,483,337.72
10	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0	30,801,070.64	30,801,070.64
11	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0	30,801,070.64	30,801,070.64
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0	30,801,070.64	30,801,070.64
19	Тайлант үеийн үр дүн	0	94,440,423.80	94,440,423.80
20	2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	0	125,241,494.44	125,241,494.44

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	110,529,700.00	104,766,269.00	5763431.00	94.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	110,529,700.00	104,766,269.00	5763431.00	94.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	110,332,900.00	104,766,269.00	5566631.00	95.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	93,253,600.00	88,564,661.00	4688939.00	95.0
210101	Үндсэн цалин	60,997,300.00	58,789,869.00	2207431.00	96.4
210102	Нэмэгдэл	23,209,500.00	22,058,316.00	1151184.00	95.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,579,200.00	3,681,000.00	898200.00	80.4
210104	Урамшуулал	4,467,600.00	4,035,476.00	432124.00	90.3
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	11,656,700.00	11,104,241.00	552459.00	95.3
210201	Тэтгэврийн даатгал	7,926,600.00	7,374,141.00	552459.00	93.0
210202	Тэтгэмжийн даатгал	932,500.00	932,500.00	0.00	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	746,000.00	746,000.00	0.00	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	186,500.00	186,500.00	0.00	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	1,865,100.00	1,865,100.00	0.00	100.0
2104	Хангамж, бараа материалын зардал	1,493,700.00	1,223,300.00	270400.00	81.9
210401	Бичиг хэрэг	216,100.00	216,100.00	0.00	100.0
210402	Тээвэр, шатахуун	478,400.00	208,000.00	270400.00	43.5
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	448,200.00	448,200.00	0.00	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	351,000.00	351,000.00	0.00	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,521,300.00	2,521,300.00	0.00	100.0
210604	Урсгал засвар	2,521,300.00	2,521,300.00	0.00	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,155,200.00	1,100,367.00	54833.00	95.3
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	110,400.00	74,250.00	36150.00	67.3
210803	Даатгалын үйлчилгээ	168,100.00	168,100.00	0.00	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	71,500.00	71,500.00	0.00	100.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	18,600.00	0	18600.00	0.0
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	786,600.00	786,517.00	83.00	100.0

Баянхонгор аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтэс 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Код	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	252,400.00	252,400.00	0.00	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	252,400.00	252,400.00	0.00	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	196,800.00	0	196800.00	0.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	196,800.00	0	196800.00	0.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	196,800.00	0	196800.00	0.0
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	110,529,700.00	104,766,269.00	5763431.00	94.8
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	110,529,700.00	104,766,269.00	5763431.00	94.8
310001	Улсын төсвөөс санхүүжих	110,529,700.00	104,766,269.00	5763431.00	94.8
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	13	13		
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1		
610001	Төсвийн байгууллага	1	1		
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	6	6		
620001	Удирдах ажилтан	1	1		
620002	Гүйцэтгэх ажилтан	5	5		
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	6	6		
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	6	6		

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		Өмнөх он	Тайлант он
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	141,438,260.0	260,920,072.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	141,438,260.0	260,920,072.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	141,438,260.0	256,120,072.3
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	141,438,260.0	256,120,072.3
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	141,438,260.0	256,120,072.3
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	00.0	4,800,000.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	00.0	4,800,000.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		4,800,000.0
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	145,681,839.0	260,971,291.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	145,681,839.0	260,971,291.0
131103	ЭГНХ,ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	13,000,000.0	10,600,000.0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	129,681,839.0	250,325,695.0
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,000,000.0	45,596.0
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Баянхонгор аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтэс нь “Улс төрийн аливаа нөлөөлөлд автахгүйгээр эдийн засаг, нийгэм, хүн ам зүйн талаарх шинжлэх ухааны арга зүйгээр тооцсон статистикийн үнэн бодит мэдээлэл, судалгаагаар төр засаг, иргэн, байгууллагад адил тэгш үйлчлэхэд оршино” гэсэн эрхэм зорилгынхоо хүрээнд үйл ажиллагааныхаа зорилтыг тодорхойлжээ.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт *ороогүй* байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудит/аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтэс 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь Статистикийн үндэсний хорооноос баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг нягтлан бодох бүртгэлд ашиглаж санхүүгийн тайлан бэлтгэхдээ мөрдөж ажиллаж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баянхонгор аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтэс 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 97,114.2 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/					
	Эхний үлдэгдэл		Эцсийн үлдэгдэл		Өөрчлөлт	
	Дүн	Эзлэх хувь	Дүн	Эзлэх хувь	Дүн	Хувь
А	1	2	3	4	5	6
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	3,064.4	9.9%	3,868.1	3.0%	803.7	26.2%
Мөнгөн хөрөнгө	-	0.0%	-	0.0%	-	0.0%
Авлага	-	0.0%	-	0.0%	-	0.0%
Урьдчилгаа	-	0.0%	-	0.0%	-	0.0%
Бараа материал	3,064.4	9.9%	3,868.1	3.0%	803.7	26.2%
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	27,736.6	90.1%	124,047.1	97.0%	96,310.5	347.2%
Үндсэн хөрөнгө	102,482.4	332.7%	212,182.4	165.9%	109,700.0	107.0%
Хуримтлагдсан элэгдэл	(74,745.7)	-242.7%	(88,135.2)	-68.9%	(13,389.5)	17.9%
Нийт хөрөнгө	30,801.1	100.0%	127,915.3	100.0%	97,114.2	315.3%
Өр төлбөр	-	0.0%	2,673.8	2.1%	2,673.8	0.0%
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	30,801.1	100.0%	125,241.5	97.9%	94,440.4	306.6%
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	30,801.1	100.0%	127,915.3	100.0%	97,114.2	315.3%

Бараа материалын дансны үлдэгдэл 3,868.1 мянган төгрөг болж 803.7 мянган төгрөгөөр өссөн нь бичиг хэргийн материал дансны үлдэгдэл өмнөх оноос 404.5 мянга, аж ахуйн материал данс 399.2 мянган төгрөгөөр төгрөгөөр өссөн нь голлох нөлөөг үзүүлж байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 212,182.4 мянган төгрөг болж 109,700.0 мянган төгрөгөөр өссөн нь Үндэсний статистикийн хорооны даргын 2022 оны А/230 дугаар тушаалаар 80,000.0 мянган төгрөгийн өртөг бүхий Сузуки Жимни автомашин, 29,700.0 мянган төгрөгийн өртөг бүхий компьютер тоног төхөөрөмжийг шилжүүлэн авч бүртгэсэнтэй холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 125,241.5 мянган төгрөг болж 94,440.4 мянган төгрөгөөр өссөн нь нийт хөрөнгийн дансны өсөлт бууралтын 97,114.2 мянган төгрөгөөр нэмэгдэж, шинээр нэмэгдсэн тайлант үеийн үр дүнгээр хуримтлагдсан 2,673.8 мянган төгрөгөөр буурсантай холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 158,519.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас бараа, ажил үйлчилгээний зардлыг 45,626.3 мянга, нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлыг 49.2 мянган төгрөгөөр бууруулж баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 1,029.4 мянган төгрөгөөр хасаж тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 110,529.7 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 110,529.7 мянган төгрөгийн санхүүжилтийг бүрэн олгосон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 104,766.3 мянган төгрөг буюу 94.8 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 5,763.4 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

		/мянган төгрөгөөр/			
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	70405 Албан ёсны статистик	110,529.7	104,766.3	5,763.4	94.8%
2	80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	110,222.5	104,692.0	5,530.5	94.8%
3	80215 Эрдэм шинжилгээ, судалгааны ажил	110.4	74.3	36.1	67.3
4	80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж	196.8	0	196.8	0

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас 250,371.3 мянга, Засаг даргын нөөц хөрөнгөөс 10,600.0 мянга нийт 260,971.3 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, өрхийн нийгэм эдийн засгийн судалгаанд 116,041.8 мянга, албан хөдөлмөр эрхлэлтийн судалгаанд 5,024.4 мянга, хүүхдийн хөдөлмөрийн судалгаанд 14,064.6 мянга, ардчилсан засаглалын судалгаанд 353.6 мянга, хөдөө аж ахуйн тооллогод 81,913.1 мянга, өрхийн ус хангамж, ариун цэврийн байгууламжийн судалгаанд 24,825.0 мянган төгрөг, бусад судалгаа, урсгал үйл ажиллагааны зардалд 18,697.7 мянга нийт 260,920.1 мянган төгрөгийг зарцуулж 51.2 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баянхонгор аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтэс 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Нарангэрэл гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер А.Цээням, Газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтэс 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлгэх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээ сарын 20-ны өдрийн 03 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 276,545.2 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 4,148.2 мянга, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 2903.7 мянган төгрөгөөр , тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор 2022 оны тээвэр шатахууны зардлыг 510.0 мянга буюу 29%, бичиг хэргийн зардлыг 298.2 мянга буюу 42%-иар хэмнэсэн бөгөөд нийт 808.4 мянган төгрөгийн хэмнэлт бий болгосон байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар шилэн дансны нэгдсэн цахим хуудаст цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 341,593.9 мянган төгрөгийн 31 гүйлгээ, өмч хөрөнгөтэй холбоотой 4 шийдвэрийн мэдээллийг хуулийн хугацаанд бүрэн мэдээлсэн байна.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар алдаа зөрчил илрээгүй байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Байхгүй

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1,810.9 мянган төгрөгийн 3 алдаа¹ илэрснээс аудитын явцад залруулав. Үүнд:

1. Санхүүгийн тайланд байгууллагад өгөх өглөгийг 281.6 мянга, Сангийн яамны и-тайланд ажилчидтай холбоотой өглөгийг 281.6 мянган төгрөгөөр тайлагнасан байна.

2. Тайлант хугацааны улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх зардлын төлөвлөгөөг төсвийн гүйцэтгэлийн тайланд зөрүүтэй тайлагнасан.

3. Тайлант хугацааны мөнгөн гүйлгээний журналыг тулгахад 1403.4 мянган төгрөгийн и баримтгүй 5 гүйлгээг бүртгэсэн байна.

Аудитаар нийт 330.7 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс зөрчлийг давтан гаргуулахгүй байх 1 зөвлөмж өгсөн.

5.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

1. Дотоод хяналт, хариуцлагатай холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлант хугацааны цалингийн зардлыг тулгахад 12 дугаар сард 2 ажилтны нийт 330.7 мянган төгрөгийн цалинг нийгмийн даатгалд дутуу мэдээлсэн байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 ” үнэн зөв байх, Нийгмийн даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 “Энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 2, 4 дэх хэсэгт заасан даатгуулагч болон ажил олгогч нь дор дурдсан хувь хэмжээгээр сар бүр нийгмийн даатгалын шимтгэл төлнө”, 17 дугаар зүйлийн 17.1 “Ажил олгогч болон энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан даатгуулагч нь шимтгэл төлөх талаар дор дурдсан үүрэг хүлээнэ” гэсэн заалтуудыг зөрчсөн.

Өгсөн зөвлөмж: Ажиллагсадын нийгмийн даатгалын санд мэдээлээгүй 330.7 мянган төгрөгийн цалинг нөхөн мэдээлж, цаашид алдаа зөрчлийг давтан гаргуулахгүй байх зөвлөмжийг өгөв.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 05 дугаар сарын 15 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй	
							Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайланд буруу бүртгэсэн	2	407.5			2	407.5	2	407.5		
Санхүүгийн тайланд бүртгээгүй	1	1,403.4	1	1,403.4			1	1,403.4		
Дүн	3	1,810.9	1	1,403.4	2	407.5	3	1,810.9		

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/						
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Тайлант хугацааны цалингийн зардлыг тулгахад 12 дугаар сард 2 ажилтны нийт 330.7 мянган төгрөгийн цалинг нийгмийн даатгалд дутуу мэдээлсэн байна.	1	330.7						1	330.7
Нийт дүн	1	330.7						1	330.7